

**“Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний
өртгийг бууруулах (TLF) дэд хөтөлбөр”-ийн
зээлийн анхны ашиглалт гарлаа**

Монголбанкнаас гадаад худалдааны тээвэр, ложистикийн дэд бүтцийг сайжруулах замаар өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн жигд тасралтгүй байдлыг хангах, үнийн өсөлтийг хязгаарлах зорилготой TLF дэд хөтөлбөрийг Зам, тээврийн яамтай хамтран 2012.10.26-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж байна.

Зам, тээврийн яамнаас дэд хөтөлбөрт тусгагдсан зорилтод ажлуудыг талууд шат дараалалтайгаар авч хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ удаа ачаа тээвэрлэлтийн өртгийг бууруулах зорилтын хүрээнд дэд хөтөлбөрт оролцогч банкаар дамжуулан Монгол-Оросын хамтарсан “Улаанбаатар төмөр зам” ХНН-д жилийн 3.8%-ийн хүүтэй, 3 жилийн хугацаатай 22.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2013 оны 3 дугаар сарын 22-ны өдөр олголоо.

TLF дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч “Улаанбаатар төмөр зам” ХНН нь энэхүү зээлийн эх үүсвэрээр өөрсдийн хэрэгцээний шатахуун худалдан авалтыг бие даан гүйцэтгэж эхэлснээр төмөр замын тээвэрлэлтийн зардлаа бууруулах боломжтой болж байна.

Дэд хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Монголбанкны цахим хуудасны “Үнийг тогтворжуулах хөтөлбөр” цэснээс үзнэ үү.

<http://www.mongolbank.mn/pricestability.aspx>